



ДАРАА ТӨЛБӨРТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

НЭГ. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

- 1.1 Энэхүү Дараа төлбөрт үйлчилгээний нөхцөлд дараах нэр, томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
- 1.1.1 **“Бүртгэлийн хураамж”** гэж шинэ хэрэглэгчийн дугаарын нэг удаагийн, эргэн төлөгдөхгүй төлбөрийг;
- 1.1.2 **“Барьцаа төлбөр”** гэж Хэрэглэгч хэрэглээний төлбөр төлөх үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор хэрэглэгчээс урьдчилан төвлөрүүлсэн хөрөнгийг;
- 1.1.3 **“Сарын суурь хураамж”** гэж Хэрэглэгч нь үйлчилгээ үзүүлэгчийн сүлжээ ашигласнаар сар бүр тогтмол төлөх төлбөрийг;
- 1.1.4 **“Багцын хэрэглээний эрх”** гэж Хэрэглэгчийн ашиглаж буй багцын сарын суурь хураамжид багтаж буй (яриа, мессеж, дата эрх) үйлчилгээний эрхийг;
- 1.1.5 **“Нэмэлт үйлчилгээ”** гэж хэрэглэгчийн ашиглаж байгаа яриа, мессеж, дата хэрэглээнээс бусад нэмэлтээр үзүүлж буй үйлчилгээг;
- 1.1.6 **“Үйлчилгээний төлбөр”** гэж Хэрэглэгчийн дугаарт бодогдсон тухайн сарын хэрэглээний төлбөр, сарын суурь хураамж, бусад холбогдох төлбөр, хөнгөлөлт болон НӨАТ зэргийн нийлбэр дүнж;
- 1.1.7 **“Үйлчилгээ хооронд шилжих”** гэж Хэрэглэгч дугаар солилгүйгээр ашиглаж буй багцаа өөрчлөхийг;
- 1.1.8 **“Дугаар хадгалах үйлчилгээ”** гэж Хэрэглэгч дугаараа ашиглахгүй тохиолдолд үйлчилгээний салбарт хандаж 12 сар хүртэлх хугацаанд бүрэн хаалгаж, хадгалуулах үйлчилгээг;
- 1.1.9 **“Хэрэглэгчийн хүсэлтээр дугаарыг түр хаах”** гэж Хэрэглэгч дугаараа ашиглахгүй тохиолдолд үйлчилгээний салбарт хандаж 3 сар хүртэлх хугацаанд үйлчилгээний эрхээ бүрэн хаалгаж үйлчилгээг;
- 1.1.10 **“Эзэмших эрх шилжүүлэх”** гэж Хэрэглэгч өөрийн нэр дээр эзэмшиж буй дугаарыг бусдад шилжүүлэх үйлчилгээг;
- 1.1.11 **“Дугаар солих”** гэж Хэрэглэгчийн эзэмшиж буй дугаарын сүүлийн 4 оронг солих үйлчилгээг;
- 1.1.12 **“Сим карт сэргээх”** гэж Хэрэглэгч шинээр Сим карт худалдан авахыг;
- 1.1.13 **“Хэрэглээний дэлгэрэнгүй жагсаалт”** гэж Хэрэглэгчийн гарах яриа, мессеж хэрэглээ хийсэн дугаарын жагсаалт болон бодогдсон төлбөрийн мэдээллийг;
- 1.1.14 **“Үйлчилгээ зогсоох”** гэж орох гарах яриа, мессеж, дата үйлчилгээний эрхийг зогсоох;
- 1.1.15 **“Биллинг цикл”** гэж сарын эхний өдрөөс сарын сүүлийн өдөр дуусгах хугацааг;
- 1.1.16 **“Зүй зохисгүй хэрэглээ”** гэж үйлчилгээ үзүүлэгчийн дугаар бүхий Сим картанд тусгай зориулалтын төхөөрөмж, програм хангамж холбож, зөвшөөрөлгүйгээр нэг дор их эмжээний дуут сурталчилгаа/Voice broadcast/, дуудлага ашиглан сурталчилгаа түгээх/outbound call center/, мессеж сурталчилгаа /SMS broadcast/ явуулах, бооцоот тоглоом болон хууль бус, тусгай зөвшөөрөлгүй гэдү ажиллагаа сурталчилсан, түгээсэн, бусдыг доромжилсон, ялгаарлан гадуурхсан, хууль бус үйлдэл хийхийг урьдсан, дарамт үзүүлсэн, Үйлчилгээ үзүүлэгч болон бусад операторын сүлжээнд хор нөлөө үзүүлж ашигласан, болон үүгээр хязгаарлагдахгүй хууль, дүрэм, гэрээнд хорилосон үйлдэл гаргасан, ашигласан.
- 1.1.17 **“Олон Улсын ярианы үйлчилгээ”** гэж олон улсын ярианы үйлчилгээний барьцаа байршуулсан хэрэглэгч 002 гарцыг ашиглан гадаад улс руу дуудлага хийх, мессеж илгээх үйлчилгээг;
- 1.1.18 **“Олон Улсын Роуминг үйлчилгээ”** гэж гадаад улсад зорчихдоо өөрийн дугаараа ашиглан зөвхөн үйлчилгээ үзүүлэгчтэй хамтран ажиллах гэрээ байгуулсан гадаадын операторуудын сүлжээг ашиглах үйлчилгээг;
- 1.1.19 **“Хурууны хээ уншуулагч”** гэж Төрийн мэдээлэл солилцооны ХҮР системийн мэдээлэлд үндэслэн хэрэглэгчийн хурууны хээг таньж, улсын бүртгэлийн мэдээллийг хэрэглэгчийн мэдээллийн санд татан авах зориулалт бүхий төхөөрөмжийг;
- 1.1.20 **“4G LTE үйлчилгээ”** гэж Үүрэн холбооны 4-дэгч үеийн LTE (Long Term Evolution) технологи ашигласан хөдөлгөөнт, өндөр хурдны Интернетийн үйлчилгээг;
- 1.1.21 **“Баталгаат гарын үсэг”** гэж гарын үсгийн баталгаа авах хуудаст зурсан Хэрэглэгчийн гарын үсгийг;
- 1.1.22 **“eSIM”** гэж үйлчилгээ үзүүлэгчээс өгсөн QR кодыг уншуулж өөрийн гар утас, төхөөрөмжинд биет бус Сим картаар дугаар суулган ашиглах үйлчилгээг;
- 1.1.23 **“ДАН систем”** гэж Танилт нэвтрэлтийн нэгдсэн систем буюу иргэнийг цахим орчинд таньж баталгаажуулан ХҮР системээс улсын бүртгэл дэх иргэний мэдээллийг үйлчилгээ үзүүлэгчийн мэдээллийн санд татан авах үйлчилгээг;
- 1.1.24 **“Тоон гарын үсэг”** гэж цахим баримтад зурагдсан гарын үсэг юм. Энэ нь МУ-ын “Цахим гарын үсгийн тухай хууль”-ийн дагуу энгийн гарын үсэгтэй адил хэрэглэгдэнэ. Таны хэвлэмэл материалд үзгээр зурсан гарын үсэгтэй ижил үүрэг, зорилготой баталгаажуулалтын нэг арга, хэлбэр юм.
- 1.1.25 **“PKI SIM”** гэж өндөр нууцлал бүхий тусгай зориулалтын сим карт юм. Үүн дээр таны тоон гарын үсэгний гэрчилгээ болон утасны дугаар байрладаг.
- 1.1.26 **“Тоон гарын үсгийн гэрчилгээ”** гэж хэрэглэгчийн хувийн мэдээллийг агуулсан цахим баримт бичиг юм. Мөн энэ нь таны тоон гарын үсэг эзэмших эрх, тоон гарын үсгийн нийтийн түлхүүр, холбогдох бусад мэдээллийг агуулсан байна. Энэхүү баримт бичиг нь баталгаажсан биет болон цаасан гэрчилгээний адил үйлчилнэ.

ХОЁР. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

- 2.1 **Шинэ хэрэглэгч болох**
- 2.1.1 Дараах тохиолдолд шинэ хэрэглэгч болох боломжтой. Үүнд:
 - Үйлчилгээний салбарт хандан өөрийн цахим үнэмлэх, хурууны хээ уншигчид мэдээллэх өгч;
 - Цахим орчинд ДАН системийн мэдээллэх өгч;
 - Тоон гарын үсэг ашиглах эрх бүхий PKI сим карт авч;
- 2.2 **Бүртгэлийн хураамж**
- 2.2.1 Шинэ хэрэглэгч Хавсралт 2.1-д заасан бүртгэлийн хураамж болон барьцаа төлбөрийг байршуулна.
- 2.2.2 eSIM сонгосон хэрэглэгч Хавсралт 1.1-д заасан бүртгэлийн хураамж болон барьцаа төлбөр дээр нэмж Хавсралт 2.1-д заасан QR кодын төлбөрийг төлнө.
- 2.2.3 PKI SIM сонгосон хэрэглэгч бүртгэлийн хураамж болон барьцаа төлбөр дээр нэмж тоон гарын үсэг агуулсан сим картын төлбөр, гэрчилгээний төлбөр, жилийн хураамж төлбөрийг нэмж төлнө;
- 2.2.4 Хэрэглэгч азын, алтан, үнэ цэнтэй дугаар худалдан авах бол Хавсралт 1.1 болон Хавсралт 1.1.1-д заасан нэмэлт төлбөрийг төлнө.
- 2.3 **Сарын суурь хураамж**
- 2.3.1 Хэрэглэгч дараах нөхцөлүүдэд сарын суурь хураамж төлөхгүй. Үүнд:
 - 2.3.1.1 Хэрэглэгч дугаар хадгалуулах үйлчилгээг авсан;
 - 2.3.1.2 Хэрэглэгчийн хүсэлтээр дугаарыг тухайн сарын эхний өдрөөс түр хаасан;
 - 2.3.1.3 Гэрээнд заасны дагуу үйлчилгээ үзүүлэгчийн санаачлагаар хэрэглэгчийн үйлчилгээг бүхэлд нь зогсоосон.
- 2.3.2 Гар утас эзэлээр эсвэл хөнгөлөлттэй нөхцөлөөр авсан хэрэглэгчид 2.3.1.1,

- 2.3.1.2, 2.3.1.3 заалтууд хамаарахгүй.
- Сарын дундуур шинэ хэрэглэгч болсон тохиолдолд зөвхөн тухайн сарын суурь хураамжийг Хавсралт 1.2-т заасан нөхцөлийн дагуу нэхэмжлэх бөгөөд багцад дагалдах хэрэглээний эрхийг бүтэн олгоно.
- Урьдчилсан төлбөрт үйлчилгээнээс дараа төлбөрт үйлчилгээ рүү сарын аль ч өдөр шилжсэн тохиолдолд сарын суурь хураамж бүтнээр тооцогдоно.
- Хэрэглэгч сарын турш хэрэглээ хийгээгүй, дугаар хадгалах үйлчилгээнд бүртгүүлээгүй тохиолдолд Хавсралт 1.3-д заасан дугаар хадгалах үйлчилгээний төлбөр хэрэглээ хийгээгүй сар бүр нэхэмжлэгдэнэ.
- Багцын хэрэглээний эрх**
- Багцын дата эрхийг Скайтелийн 3G болон 4G LTE сүлжээнд ашиглах боломжтой ба дата эрх дууссаны дараах хэрэглээ нь Хавсралт 2.2-д заасан задгай дата тарифаар тооцогдоно.
- Багцын ярианы эрхийг Скайтелийн сүлжээнд болон харилцан холболт бүхий дотоодын сүлжээнд ашиглах боломжтой бөгөөд зүй зохисгүй хэрэглээс сэргийлж зохист хэрэглээний хязгаартай байна.
- Багцын мессеж эрхийг Скайтелийн сүлжээнд болон харилцан холболт бүхий дотоодын операторуудын сүлжээнд ашиглах боломжтой ба зүй зохисгүй хэрэглээс сэргийлж, 1 өдрийн хэрэглээ 150 мессежээр хязгаарлана.
- Тусгай дугаарын яриа, видео дуудлага, Олон Улсын яриа болон Олон Улсын Роуминг ярианы хэрэглээ багцын ярианы эрхэд хамаарахгүй.
- Багцын хэрэглээний эрхийг ашиглах нөхцөл:
 - Тухайн сардаа ашиглаж дуусаагүй ярианы эрхийн хэрэглээ дараагийн 1 сард шилжинэ.
 - Багц шилжсэн тохиолдолд өмнөх сардаа ашиглаж дуусаагүй ярианы эрхийн хэрэглээ дараагийн сард шилжихгүй.
 - Тухайн сардаа ашиглаж дуусаагүй дата эрхийн хэрэглээ дараагийн сард шилжихгүй.
- Үйлчилгээний хугацаа**
- Дараа төлбөрт үйлчилгээний гэрээг байгуулсан өдрөөс эхлэн үйлчилгээний хугацааг тооцно.
- Дараа төлбөрт үйлчилгээний гэрээг цуцалсан өдрөөр үйлчилгээний хугацаа дуусгавар болно.
- PKI сим карт авсан дараа төлбөрт үйлчилгээний хэрэглэгчийн тоон гарын үсэг ашиглах үйлчилгээний хугацаа 12 сар байна. Үйлчилгээний хураамж 5000 төгрөг ба үйлчилгээ авах үед төлбөрийг төлнө;
- Сим карт сэргээх**
- Хэрэглэгч үйлчилгээний салбарт хандан Хавсралт 2.4-д заасан тарифаар Сим картаа сэргээлгэнэ.
- Хэрэглэгч ашиглаж буй төхөөрөмжөө сольж өөр төхөөрөмжд eSIM-ийг ашиглах бол үйлчилгээний салбар, онлайн суваг ашиглан Хавсралт 2.4-д заасан тарифаар шинэ QR код худалдан авна.
- Хэрэглэгч үйлчилгээний салбарт хандан 11000 төгрөг төлж өндөр нууцлал бүхий PKI сим картаа сэргээлгэнэ;
- ГУРАВ. ЗАХИАЛГАТ ҮЙЛЧИЛГЭЭ**
- 3.1 **Багц хооронд шилжих**
- 3.1.1 Багц хооронд шилжих гэдэг нь дугаараа солихгүйгээр багцын төрлөө өөрчлөхийг хэлэх ба гар утас эзлээр эсхүл хөнгөлөлттэй нөхцөлөөр авсан хэрэглэгч багцаа бууруулах боломжгүй.
- 3.1.2 Багц хооронд шилжих үйлчилгээний хүсэлтийг сарын аль ч өдөр хүлээн авах бөгөөд үйлчилгээ нь зөвхөн дараа сарын 01-ний өдөр, идэвхтэй төлөвтэй дугаарт идэвхэжнэ.
- 3.1.3 Үйлчилгээний үнэ тарифт заасан нөхцөлийн дагуу сонгосон багцад харгалзах барьцаа төлбөрийг байршуулан багц хооронд шилжих боломжтой.
- 3.1.4 Багц ахиулах тохиолдолд нэмэлт төлбөр төлөхгүй ба багц бууруулах тохиолдолд Хавсралт 2.4-д заасан төлбөрийг төлнө.
- 3.1.5 Хэрэглэгч багцаа бууруулах тохиолдолд шатлан буурах зарчмаар үйлчилгээг үзүүлнэ.
- 3.2 **Дугаар хадгалах үйлчилгээ**
- 3.2.1 Хэрэглэгчийн хүсэлтээр дугаарын үйлчилгээний эрхийг төлбөртэй нөхцөлөөр түр хаах боломжтой бөгөөд гар утас эзлээр эсхүл хөнгөлөлттэй нөхцөлөөр авсан хэрэглэгч дугаараа хадгалуулах боломжгүй.
- 3.2.2 Хэрэглэгч дугаараа хадгалуулах тохиолдолд үйлчилгээний салбарт өөрийн биеэр цахим үнэмлэх эсвэл хурууны хээ уншигчийн мэдээллийг өгч тухайн өдрөөс эхлэн хадгалуулах ба өмнөх төлбөр тооцоог бүрэн төлж барагдуулна.
- 3.2.3 Үйлчилгээг 3 ба түүнээс дээш сар ашигласан хэрэглэгч дугаар хадгалах үйлчилгээнд хамрагдах боломжтой ба дугаар хадгалах үйлчилгээний төлбөрөө урьдчилан төлнө.
- 3.2.4 Хэрэглэгч дугаараа жилд /хуанлийн бүтэн жилээр тооцно/ 3 сар дараалан үнэ төлбөргүй хадгалуулах боломжтой.
- 3.2.5 Хэрэглэгч эхний удаа 3 ба түүнээс доош сар үнэгүй хадгалуулсан тохиолдолд тухайн жилийн хугацаанд дахин үнэгүй хадгалуулах боломжгүй.
- 3.2.6 Хэрэв 3 сараас дээш хугацаанд дугаараа хадгалуулах тохиолдолд 4 дэх сараас эхлэн Хавсралт 2.4-д заасан төлбөртэй нөхцөлөөр нэг удаад 12 сараас ихгүй хугацаагаар хадгалуулах боломжтой.
- 3.2.7 Хэрэглэгч сарын дундуур дугаар хадгалуулах хүсэлт гаргасан бол үйлчилгээний сарын суурь хураамжийг бүтэн нэхэмжлэн суурь хураамжид дагалдах эрхийг бүтэн олгох бөгөөд дугаар хадгалуулах хүсэлт гаргасан тухайн өдөрт нь идэвхжүүлж, үйлчилгээний эрхийг бүрэн хаана.
- 3.2.8 Дугаар хадгалах хугацаа дуусахад дугаарын эрх автоматаар нээгдэх бөгөөд хэрэглээ хийгээгүй сар бүр Хавсралт 1.3-д заасан төлбөр нэхэмжлэгдэнэ.
- 3.3 **Хэрэглэгчийн хүсэлтээр дугаар нэхэ**
- 3.3.1 Хэрэглэгч дугаараа нээлгэх хүсэлт гаргасан тохиолдолд үйлчилгээний салбарт өөрийн биеэр цахим үнэмлэх эсвэл хурууны хээ уншигчийн мэдээллийг өгч дугаарыг тухайн өдрөөс эхлэн нээлгэнэ.
- 3.3.2 Сарын дундуур үйлчилгээ нээлгэх хүсэлт гаргаж байгаа тохиолдолд үйлчилгээний суурь хураамж бүтнээр бодогдож үйлчилгээний эрхийг бүтэн олгоно.
- 3.3.3 Хэрэглэгч дугаараа нээлгэх үед төлбөрийн үлдэгдэлтэй бол төлбөрөө бүрэн барагдуулах үүрэгтэй.

3.4 Үйлчилгээ хооронд шилжих

- 3.4.1 Урьдчилсан төлбөрт үйлчилгээнээс Дараа төлбөрт үйлчилгээ рүү шилжихэд Хавсралт 2.1-д заасан харгалзах багцын барьцаа төлбөрийг төлнө.
- 3.4.2 Хэрэглэгч дараа төлбөрт үйлчилгээнээс буцаж урьдчилсан төлбөрт үйлчилгээ рүү шилжих тохиолдолд тухайн үйлчилгээг 3 сараас дээш хугацаанд тасралтгүй ашигласан байх ба үйлчилгээний нийт төлбөр болон Хавсралт 2.4-д заасан төлбөрийг төлнө.
- 3.4.3 Хэрэглэгч үйлчилгээ хооронд шилжих тохиолдолд өмнө нь Урьдчилсан төлбөрт нөхцөл дээр ашиглаж байсан хугацаа нэгж устгах ба үйлчилгээний хугацаа тус өдрөөр 0 нэгжтэй шилжинэ.

ДӨРӨВ. ДУГААР СОЛИХ

- 4.1 Хэрэглэгч дугаарын сүүлийн 4 оронг солих тохиолдолд үйлчилгээний салбарт өөрийн биеэр хандах ба цахим үнэмлэх эсвэл хурууны хээ уншигчийн мэдээллийг үндэслэн хүсэлт гаргасан тухайн өдөрт нь үйлчилгээг идэвхжүүлж өгнө.
- 4.2 Дугаарын сүүлийн 4 оронг солих тохиолдолд Хавсралт 2.4-д заасан төлбөртэй нөхцөлөөр солих бөгөөд хэрэглэгчийн дугаарын багцад дагалдах хэрэглээний эрх болон нэмэлт үйлчилгээний эрхийг хэвээр шилжүүлнэ.
- 4.3 Дугаар солих үйлчилгээг гар утас эзэлээр эсхүл хөнгөлөлттэй нөхцөлөөр авсан хэрэглэгч авах боломжгүй.

ТАВ. ЭЗЭМШИХ ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ

- 5.1 Эзэмших эрх шилжүүлэх тохиолдолд эзэмших эрх шилжүүлэгч болон эзэмших эрх хүлээн авагч тус тус өөрийн биеэр салбарт хандах ба цахим үнэмлэх эсвэл хурууны хээ уншигчийн мэдээллийг өгч эзэмших эрх шилжүүлнэ.
- 5.2 Эзэмших эрх шилжүүлэх тохиолдолд сар бүрийн 06-ны өдрөөс эхлэн шилжүүлэх бөгөөд нийт төлбөрийн үлдэгдлийг бүрэн барагдуулсан байна.
- 5.3 Эзэмших эрх шилжүүлсэн тохиолдолд хүлээн авсан хэрэглэгчтэй Дараа төлбөрт үйлчилгээний гэрээг шинээр байгуулна.
- 5.4 Гар утас эзэлээр эсхүл хөнгөлөлттэй нөхцөлөөр авсан хэрэглэгч эзэмших эрх шилжүүлэх боломжгүй.
- 5.5 Дараах хүндэтгэх шалтгаанаар эзэмших эрх шилжүүлэх боломжтой. Үүнд:
- 5.5.1 Дугаар эзэмшигч нас барсан тохиолдолд:
- Эзэмшигчийн нас барсны гэрчилгээ;
 - Эзэмшигчийн гэр бүлийн гишүүн /гэр бүлийн гишүүн гэдгийг эзэмшигчийн эхнэр, нөхөр, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, насанд хүрсэн төрсөн, дагавар болон үрчилж авсан хүүхэд, төрсөн ах, эгч, дүү/ болохыг нотолсон лавлагаа;
 - Дугаарын эрх шилжүүлэн авагч нь цахим үнэмлэх эсвэл хурууны хээ уншигчийн мэдээллээр өөрийн нэр дээр шилжүүлэн авна.
- 5.5.2 Дугаар эзэмшигч гадаад улсад амьдарч байгаа тохиолдолд:
- Тухайн улсад /гадаадад/ оршин сууж буйг нотолсон баримт бичиг;
 - Гадаад паспортын хуулбар, визийн хамт;
 - Дугаар эзэмшигч цахим үнэмлэх болон хүлээн авагчийн цахим үнэмлэх эсвэл хурууны хээ уншигчийн мэдээллийг үндэслэх;
 - Дугаарын эзэмших эрхээ шилжүүлэхийг зөвшөөрсөн тухай баталгаат гарын үсэгтэй өргөдөл, хүсэлтийг баталгаажуулсан байх.

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН РОУМИНГ ҮЙЛЧИЛГЭЭ

- 6.1 **Мессеж Роуминг үйлчилгээ**
- 6.1.1 Мессеж роуминг үйлчилгээг дараа төлбөрт үйлчилгээний хэрэглэгч нэмэлт барьцаа төлбөр байршуулахгүйгээр ашиглах боломжтой бөгөөд мессеж хүлээн авахад үнэ төлбөргүй, илгээхэд тухайн зорчих бүс нутаг болон орнуудаас шалтгаалан харилцан адилгүй байх ба тухайн үнэ тарифтай хэрэглэгч заавал танилцсан байх үүрэгтэй.(www.skytel.mn, 1515 лавлах төв)
- 6.1.2 Мессеж роуминг үйлчилгээ нь дараа төлбөрт үйлчилгээний шинэ хэрэглэгч болох үед идэвхжих ба гадаад улс руу зорчихдоо тусгай дугаарт мессеж илгээн идэвхжүүлэх шаардлагагүйгээр шууд ашиглах боломжтой байна.
- 6.1.3 Хэрэглэгч үйлчилгээ үзүүлэгчийн сүлжээнд байхдаа 599 дугаарт “sms” гэсэн мессежийг илгээн идэвхжүүлэх боломжтой.

Яриа-мессеж роуминг

- 6.2.1 Дараа төлбөрт хэрэглэгч Яриа-мессеж роуминг үйлчилгээний эрх нээлгэхдээ үйлчилгээний салбарт хандан, Хавсралт 2.3-д заасан барьцаа төлбөрийг байршуулна.
- 6.2.2 Хэрэглэгч 12 сар болон түүнээс дээш хугацаанд дугаараа идэвхтэй ашигласан тохиолдолд Яриа-мессеж роуминг үйлчилгээг Олон Улсын Роумингийн барьцаа байршуулахгүй ашиглана.
- 6.2.3 Яриа-мессеж роуминг үйлчилгээг 6.2.1 болон 6.2.2-т заасан хэрэглэгч 599 дугаарт “call” гэсэн мессежийг илгээн идэвхжүүлэх боломжтой.

Цогц роуминг үйлчилгээ

- 6.4 Цогц роуминг үйлчилгээг зөвхөн дараа төлбөрт үйлчилгээний 3G болон 4G LTE сүлжээний хэрэглэгч Хавсралт 2.3-д заасан барьцаа төлбөрийг байршуулан Олон улсын Роуминг үйлчилгээний Гэрээ байгуулан ашиглах боломжтой бөгөөд дараах үйлчилгээг ашиглана. Үүнд:
- Дуудлага хийх, хүлээн авах;
 - Мессеж илгээх, хүлээн авах;
 - Дата ашиглан гар утаснаасаа Интернетэд холбогдох.
- 6.4.2 Хэрэглэгч цогц роуминг үйлчилгээний эрхийг салбарт хандан Хавсралт 1.4-д заасан бичиг баримтад үндэслэн идэвхжүүлнэ.
- 6.5 **Дата роуминг багц**
- 6.5.1 Дата роуминг багцын үйлчилгээг Олон улсын Роуминг үйлчилгээ идэвхжүүлсэн хэрэглэгч авах боломжтой ба дата роумингийн үндсэн багцуудыг Хавсралт 1.5-д заасан нөхцөлөөр тусгай дугаарт мессеж илгээн идэвхжүүлэн ашиглана.
- 6.5.2 Дата роуминг багцын харгалзах эрхээс хэтэрсэн дата хэрэглээг Олон улсын Роуминг үйлчилгээний задгай датаны хэрэглээний тарифаар тооцон нэхэмжилнэ.
- 6.5.3 Дата роуминг багцуудыг давхар идэвхжүүлсэн тохиолдолд багцууд зэрэг идэвхжих бөгөөд хэрэглэгчийн аль улсад байгаагаас хамаарч харгалзах улсын багцаас хэрэглээг тооцно.
- 6.5.4 Дата роуминг багцын хэрэглээ болон дуусах хугацааг шалгахдаа 599 тусгай дугаарт “data” мессежийг илгээнэ.

Хэрэглэгч Олон Улсын Роуминг үйлчилгээг ашиглахдаа дараах зүйлийг анхаарна. Үүнд:

- 6.6.1 Хэрэглэгч зорчих улсынхаа үүрэн операторын Олон Улсын Роуминг үйлчилгээний яриа, мессеж, дата үйлчилгээний тарифтай урьдчилан танилцсан байна. (www.skytel.mn – Бүтээгдэхүүн үйлчилгээ – ОУ-ын үйлчилгээ – Роуминг үйлчилгээ, 1515 лавлах төв)
- 6.6.2 Олон Улсын Роуминг үйлчилгээний тарифын мэдээллийг 1510 тусгай дугаарт тухайн улсын Олон Улсын нэрний эхний 4 үсгийг/Латин үсэг/ мессежээр илгээж мессеж хэлбэрээр авах боломжтой.
- 6.6.3 Хэрэглэгч 1510 тусгай дугаарт “R” үсгийг илгээн Олон Улсын Роуминг

- үйлчилгээний хэрэглээгээ шалгана.
- 6.6.4 Өөр операторын сүлжээнд байхдаа хэрэглээ шалгах тариф нь тухайн орны Олон улсын Роуминг үйлчилгээний мессеж илгээх тарифаар тооцогдоно.
- 6.6.5 Хэрэглэгч хэрэглээгээ тогтмол хянаж, гарсан төлбөр тооцоог бүрэн хариуцна.
- 6.6.6 Олон Улсын яриа үйлчилгээний барьцаа болон Олон Улсын Роуминг үйлчилгээнд байршуулсан барьцаа дүнгээс хамааран дотоод, гадаад хэрэглээ Хавсралт 2.3-д заасан нөхцөлөөр хязгаарлагдана.

ДОЛОО. ХЭРЭГЛЭЭНИЙ ХЯЗГААР

- 7.1 Багцад дагалдах дата эрх дуусч дата хэрэглээ задгай дата хэрэглээ рүү шилжихэд ашиглаж буй үйлчилгээний багцаас хамааран задгай дата хэрэглээг Хавсралт 1.6-д заасан нөхцөлөөр зохистой хэмжээнд хүрсэн тохиолдолд хязгаарлана.

НАЙМ. ТӨЛБӨР ТООЦОО

- 8.1 **Ярианы минутын алхам тооцоолол**
- 8.1.1 Монгол Улс доторх яриаг 1 (нэг) минутын алхмаар тооцох бөгөөд нэг минут хүрээгүй яриаг нэг бүхэл минутаар тооцно.
- 8.1.2 Олон улсын яриа нь эхний бүрэн ба бүрэн бус 6 (зургаан) секунд хүртэлх яриаг 6 секундээр, 7дахь секундээс 1 секундийн алхмаар тооцогдох бөгөөд холбогдож буй улсаас хамаарч нэг минутын ярианы тариф харилцан адилгүй байна.
- 8.2 **Хэрэглээний мэдээлэл**
- 8.2.1 Хэрэглэгч сар бүрийн 06-ны өдрөөс хойш 1510 тусгай дугаарт В үсгийг илгээж хэрэглээний төлбөрийг, U үсгийг илгээж хэрэглээний мэдээллийг, D үсгийг илгээж дата хэрэглээний мэдээллийг тус тус мессеж хэлбэрээр авах боломжтой. Хэрэглээний дэлгэрэнгүй жагсаалт нь тухайн дугаарын сүүлийн 3 сарын зөвхөн гарах яриа, мессеж, дата хэрэглээ, тэдгээрт бодогдсон төлбөр тооцооны жагсаалт хэлбэртэй байх бөгөөд захидал харилцааны аливаа агуулгагүй байна.
- 8.2.2 Тоон гарын үсэг үйлчилгээний хугацаа үйлчилгээ авсан өдрөөс 12 сар хүчинтэй ба хүчинтэй хугацаа дуусахад устана. 12 сарын гэрчилгээний төлбөр 22,000 төгрөг, PKI симний төлбөр 11,000 төгрөг байна. Шинээр үйлчилгээ авах үед төлбөрийг төлнө;
- 8.2.4 Тоон гарын үсэг ашиглах гэрчилгээний хугацаа 12 сар. Уг хугацаа нь үндсэн үйлчилгээний хугацаанаас /түр салгалт/ хамааралгүй 12 сар байна;
- 8.3 **Төлбөр төлөх боломж**
- 8.3.1 Хэрэглэгч ашигласан хэрэглээний төлбөрийг сар бүрийн 20-ны дотор дараах сувгуудаар төлөх боломжтой. Үүнд:
- 8.3.2 Үйлчилгээний салбарт хандаж;
- 8.3.3 www.skytel.mn веб хуудас, Skytel болон банкны аппликэйшн ашиглан;
- 8.3.4 Хавсралт 2.5-д заасан банкны дансаар;
- 8.3.5 Сервис дилерт хандаж;
- 8.3.6 Үйлчилгээ үзүүлэгчийн нэвтрүүлсэн бусад сувгаар;

ЕС. НЭМЭЛТ ДАТА БАГЦ

- 9.1 Нэмэлт дата багцын үнэ тариф нь үйлчилгээ үзүүлэгчийн тухайн үеийн нөхцөлөөр зохицуулагдах ба 3G болон 4G сүлжээнд ашиглах боломжтой байна. Нэмэлт дата багцыг сарын аль ч өдөр идэвхжүүлсэн сарын суурь хураамжийг бүтэн нэхэмжилж тухайн сарыг дуустал ашиглах хугацаатай байх бөгөөд багцаас хэтэрсэн хэрэглээ Хавсралт 2.2-д заасан задгай тарифаар тооцогдоно.
- 9.2 Сар бүр автоматаар сунгагдах дата багц сонгосон тохиолдолд сар бүрийн суурь хураамж дээр дата багцын үнэ нэмж нэхэмжилгэд бөгөөд хэрэглэгч өөрөө мессежээр цуцлах хүртэл дата багц сар бүр автоматаар сунгагдана.
- 9.3

АРАВ. УРАМШУУЛАЛТ ҮНЭЭР ҮНЭ ЦЭНТЭЙ БОЛОН АЗЫН ДУГААРЛАЛТ АВАХ ҮЙЛЧИЛГЭЭ

- 10.1 Дараа төлбөрт үйлчилгээний үнэ цэнтэй болон азын дугаарлалтыг урамшуулалт үнээр худалдан авсан тохиолдолд 12 сарын хугацаанд дугаар хадгалах үйлчилгээ авах боломжгүй байна.
- 10.2 Дугаарыг 12 сарын хугацаанд устгах боломжгүй байна.
- 10.3 Хавсралт үйлчилгээнд шилжүүлэн ашиглах боломжгүй байна.
- 10.4 Урамшуулалт үнээр үнэ цэнтэй дугаарыг худалдан авч байгаа тохиолдолд зөвхөн Монголдоо 20000-с дээш багцад ашиглах боломжтой байна.
- 10.5 Азын дугаарлалтыг Монголдоо 10000-с дээш багц ашиглана.

АРВАН НЭГ. ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОГСООХ

- 11.1 Тухайн сарын хэрэглээний төлбөрийг дараа сарын 20-ны дотор төлөөгүй тохиолдолд сарын сүүлийн өдөр хүртэл гарах үйлчилгээний эрхийг зогсоож, орох үйлчилгээний эрхийг хэвээр үлдээх бөгөөд сарын сүүлийн өдөр орох, гарах үйлчилгээний эрхийг төлбөр төлөх өдөр хүртэл зогсооно.
- 11.2 Багцаас хэтэрсэн яриа, мессеж, дата хэрэглээний төлбөр хэрэглээний хязгаарлалтын дүнд хүрсэн тохиолдолд гарах үйлчилгээний эрхийг төлбөр төлөх өдөр хүртэл зогсоох ба орох үйлчилгээний эрх нээлттэй байна.

АРВАН ХОЁР. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

- 12.1 Талууд дараах үндэслэлээр энэхүү гэрээг цуцлаж болно. Үүнд:
- 12.1.1 Гэрээнд заасан аль нэг үүргээ биелүүлээгүй бол;
- 12.1.2 Хэрэглэгчийн эрх зүйн чадвар дуусгавар болсноор;
- 12.1.3 Хэрэглэгчийн хүсэлтээр;
- 12.1.4 Хуульд заасан бусад үндэслэлээр.
- 12.2 Хэрэглэгч гэрээг цуцлах тухай саналыг Үйлчилгээ үзүүлэгчид ажлын 3 хоногийн өмнө мэдэгдэж үйлчилгээг хаалгана.
- 12.3 Хэрэглэгч өөрийн хүсэлтээр гэрээг цуцлах тохиолдолд үйлчилгээний төвд өөрийн биеэр цахим үнэмлэх эсвэл хурууны хээ уншигчийн мэдээллийг үндэслэн дараах төлбөрүүдийг төлж барагдуулан үйлчилгээг зогсооно. Үүнд:
- 12.3.1 Гэрээг цуцлах хүртэлх хугацаанд ашигласан үйлчилгээний нийт төлбөр;
- 12.3.2 Бусад төлбөр, зардлууд
- 12.4 Хэрэглэгч гэрээ цуцлах хүсэлтээ албан ёсоор мэдэгдээгүй болон дугаар хадгалуулах үйлчилгээ аваагүй тохиолдолд тухайн дугаарыг идэвхгүй төлөвт шилжсэнээс хойш 181 дэх хоногт барьцаа төлбөрөөс хэрэглээний нийт төлбөрийг суутгах ба барьцаа төлбөрөөс хэтэрсэн үлдэгдэл төлбөрийг хэрэглэгч бүрэн хариуцан барагдуулна.

АРВАН ГУРАВ. БУСАД

- 13.1 Энэхүү дараа төлбөрт үйлчилгээний нөхцөлд шууд заагаагүй, тусгагдаагүй бусад үйлчилгээний нөхцөлийг тухайн үед Скайтел ХХК-ийн Хэрэглэгчид үзүүлж буй үйлчилгээний нөхцөлөөр зохицуулагдах ба Дараа төлбөрт үйлчилгээний нөхцөлд Скайтел ХХК дангаараа өөрчлөлт оруулах эрхтэй.

ДАРАА ТӨЛБӨРТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦЛИЙН ХАВСРАЛТ 1

1.1 Азын ,Алтан дугаар		
Дугаарын төрөл		Нэмэлт төлбөр
Азын	AABB, ABAB, ABBA, AAAB, BAAA	60.000₮
Алтан	9BAA-9BAA	300.000₮
	AAAA	500.000₮

1.1.1 Үнэ цэнтэй дугаар			
Дугаарын төрөл		Нэмэлт төлбөр	
9111**** 9191**** 9000**** 9090****	Энгийн	50.000₮	
	Азын	AABB, ABAB, ABBA, AAAB, BAAA	100.000₮
	Алтан	AAAA	800.000₮
		9BAA-9BAA	

1.2 Шинэ хэрэглэгчийн суурь хураамж тооцох	
Шинэ хэрэглэгч болсон өдөр	Сарын суурь хураамж тооцох хувь
1-10-ны өдрүүдэд	100%
11-20-ны өдрүүдэд	50%
21-31-ний өдрүүдэд	30%

1.3 Суурь хураамж тооцох	
Хэрэглээ хийгээгүй үед тооцох нөхцөл	Сар бүр 5000₮

1.4 ОУ-ын үйлчилгээ идэвхжүүлэхэд шаардлагатай бичиг баримт	
Хувь хэрэглэгч	Цахим үнэмлэх эсвэл өөрийн биеэр хурууны хээ уншуулах
Байгууллагын хэрэглэгч	Цахим үнэмлэх эсвэл хурууны хээ уншуулах, байгууллагын албан хүсэлт

1.5 Дата роуминг багц						
Багцын нэр	Ашиглах хугацаа	Дата хэмжээ	Ашиглах улс	Үнэ тариф	Тусгай дугаар	Илгээх утга
48 цагийн багц	48 цаг	200MB	АНУ-USA, Канад-Canada	39.000₮	599	AMERICA 48
			Их Британи-UK, Орос-Russia, Франц-France, Герман-Germany	39.000₮		EUROPE 48
			Солонгос-Korea, Макао-Macau, Хонг Конг-Hong Kong, Хятад-China	39.000₮		ASIA 48
7 хоногийн ЧАТ багц	7 хоног	450MB	АНУ-USA, Канад-Canada	79.000₮		AMERICA CHAT
			Их Британи-UK, Орос-Russia, Франц-France, Герман-Germany	79.000₮		EUROPE CHAT
			Солонгос-Korea, Макао-Macau, Хонг Конг-Hong Kong, Хятад-China	79.000₮		ASIA CHAT
1GB дата	7 хоног	1GB	АНУ-USA, Канад-Canada, Их Британи-UK, Герман-Germany, Франц-France, Макао-Macau, Хятад-China	120.000₮		1GB
4GB дата	14 хоног	4GB		459.000₮		4GB

1.6 Задгай дата хэрэглээг хязгаарлах нөхцөл:	
Багц	Задгай дата хэрэглээг хязгаарлах хэмжээ
Монголдоо 10/Соёмбо 10/ Байгууллага 8000	5GB
Монголдоо 20/ Соёмбо 20	
Монголдоо 30/ Соёмбо 30	10GB
Монголдоо 40/ Соёмбо 40	
Монголдоо 70	
Монголдоо 100	

ДАРАА ТӨЛБӨРТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦЛИЙН ХАВСРАЛТ 2

Үйлчилгээний үнэ тариф	МОНГОЛдоо					
	10	20	30	40	70	100
2.1 Үндсэн үнэ						
Багцын сарын суурь хураамж	10.000₮	20.000₮	30.000₮	40.000₮	70.000₮	100.000₮
Бүртгэлийн хураамж	10.000₮					
eSIM QR код авах	5000₮					
Үндсэн барьцаа	20.000₮		30.000₮	50.000₮		

2.2 Яриа, мессеж, задгай дата хэрэглээний тариф	
Сүлжээ харгалзахгүй яриа	50₮
Сүлжээ харгалзахгүй мессеж	20₮
Завгай дата /мегабайтаар/	1MB тутамд 6₮

2.3 Олон Улсын үйлчигээ	Барьцаа төлбөр	Хэрэглээ хязгаарлах
Олон Улсын ярианы үйлчилгээ	Үндсэн барьцаа+100.000₮	100.000₮
	Үндсэн барьцаа+200.000₮	200.000₮
Яриа-мессеж хосолсон роуминг	*	200.000₮
	Үндсэн барьцаа+100.000₮	200.000₮
Цогц роуминг	Үндсэн барьцаа + 350.000₮	500.000₮
	Үндсэн барьцаа + 500.000₮	Хязгааргүй

2.4 Захиалгат үйлчилгээний төлбөр	
Багц ахиулах	Төлбөргүй
Багц буурах	5000₮
Дугаарын сүүлийн 4 орон солих	20.000₮
Дугаар хадгалах	Хуанлийн 1 жилд 3 сар үнэгүй, 4 дэх сараас эхлэн сар бүр 5000₮
Сим карт сэргээх	3000₮
eSIM QR код дахин авах	5000₮
УТУ-ээс ДТУ-рүү шилжих	Төлбөргүй
ДТУ-ээс буцаж УТУ рүү шилжих	3000₮

2.5 Дансны мэдээлэл	
ХХБ банк	499 120 987
Хас банк	500 167 8218
Хаан банк	503 801 9105
Голомт банк	110 204 6354
Төрийн банк	106 000 002 84